

ХОРЧИН АМАН АЯЛГУУ БА ГЭРЛЭХ ХУРИМЫН ЗАН ҮЙЛ

Соёл, доктор, ӨМИС

Abstract: Human dialect and the sacral are related. The sacral words are dialect's sediment and is making the product in long time development. Not only local sacrament come from the features of dialects.

But also are herited through local vocabulary. Based on Horchin province research analysis, I would analyze some words belong to wedding ceremony ritual in culture contents.

Horchin wedding ceremony is related an ancient Mongolain married ritual and concluded to save the features of tribes, local. The ritual common viewof nations which locating wherever in the world is wedding observance and it is said that «газар газрын зан, гүзээ гүзээний булан», every nation has own features, and rigour disciplines. In nation of middle south china has observance which named «drink a tea», it means «A woman must not drink a tea from two family». Also in Mongolia has same observance that named «drink a vodka», it is said «if a woman drink a vodka from 2 family, she can't go far».

Every observance has own rules, features and types and these all are make human life stable and harmonic. In nation of middle south china has observance which named «drink a tea»(一吃茶), it means «A woman must not drink a tea from two family»(一女不吃两家茶). Also in Mongolia has same observance that named «drink a vodka», it is said «if a woman drink a vodka from 2 family, she can't go far».

Every observance has own rules, features and types and these all are make human life stable and harmonic.

Түлхүүр үг: Хорчин аман аялгуу, гэрлэх хуримын зан үйл, орон нутгийн соёл

Дэлхийн хаана ч оршин суух үндэстэн ястны ёс заншлын нийтлэг нэг үзэгдэл нь гэрлэх явдал бөгөөд «газар газрын зан, гүзээ гүзээний булан» гэдэгчлэн газар газрын үндэстэн, угсаатны ураг барилдах зан үйл нь өөр өөрийн гэсэн онцлог шинжтэй, хатуу тогтсон дэг жаягтай байдаг. Дундад улсын өмнө орны хятад үндэстний дотор «цай уух 吃茶»-аар ураг тогтсоны билэгдэл болгон «нэг хүүхэн хоёр гэрийн цай уухгүй (一女不吃两家茶)» гэдэг бол зарим газар орны монголчууд «архи уух»-аар ураг тогтсоны билэгдэл болгож «хоёр гэрийн хөхүүр архи ууваас хоёр хөлийг нь тушсантай адил» гэх мэтээр ярьдаг байна.

Аливаа зан үйлийн хэлбэр болгон тодорхой агуулгатай байх бөгөөд энэхүү хэлбэр, агуулгын нэгдэл нь хүн төрөлхтний ахуй амьдралыг нэгэн хэв заншилд оруулдаг байна. Иймээс дээрх зан үйлээр илрэх болсон үг, өгүүлбэр нь гагцхүү хэлний дохио тэмдэглэл бус, зан үйлийн дохио тэмдэг байж, тухайн зан үйлийг бий болгохын зэрэгцээ тогтвортой байдлыг хангадаг. Иймээс өдөр тутмын харилцаанд өргөн хэрэглэгдэх «цай уух», «архи уух» зэрэг энгийн үгс нь үндэстэн хийгээд орон нутагт гэрлэх хуримын зан үйлийг илэрхийлэх өвөрмөц соёлын агуулга бүхий ойлголт болсон байна.

Зан үйл бол нэгтгэгч шинжтэй, ямар нэгэн зан үйл байж, зан үйлтэй холбоо бүхий үгс бий болдог [1]. Хөх нуурийн тайж нар дунд «тогатын хурим» гэж байдаг. Энэ нь хурим хийхийн өмнөх өдөр хөвгүүний талаас болгоосон бүхэл хонины

мах хийгээд уг хониныхоо эвэр, шийр, сэвс зэрэг бүгдийг бэрийн талд авчирч өгдөг. Хэрвээ ямар нэгэн хэсгийг нь дутаавал хүүхний талаас “Манай хүний аль хэсэг нь дутуу юм бэ?” гэж омогддог байна (Уудам, Өргөн, 1987, х.488-489). Нэн даруй тоог бүрэн гүйцээхээр хүргэх хонины махыг «тогадын мах» гэх ба «тогадын мах» хүргэхийг «тогадын хурим» гэдэг.

Шинжааны Цахаруудын дунд ураг барилдах тогтох явдлыг «хадаг тариа тавих»-аар билэгдэл болгодог. Энэ ёс нь хүүгийн талаас хүүхний гэрт архи, хадагтай очиж, хүүхний төрөл саданд хадагаа барьж, архиа өргөн бариад тэрхүү архи хийж очсон хөхүүртээ таван төрлийн тарианы үр хийлгүүлж авах зан үйл байдаг байна. Бэр гуйхыг таван тарианы үр гуйхтай адилтган үзэж «үр гуйх» хэмээх нь давхар, давхар билэгдлийн утга агуулгыг илэрхийлж байна. Ийнхүү «таван тарианы үр» нь хүүхэн үрийн билэгдэл болж, таван тарианы үрийг өгснөөр хүүхэн үрээ өгөхөөр зөвшөөрснийг гэрчилсэн хэрэг болж байна. Энэ мөчөөс эхлэн тэр хүүхнийг «хадаг тариа тавьсан хүүхэн» гэж нэрийддэг. Үүнээс гадна Шинжааны Илийн хасаг үндэстний өөртөө засах жвугийн Өөлдүүд «аман үгийг нь аваад алчуурандаа боов» хэмээн «алчуур хадаг тавих»-аар ураг барилдахыг билэгдэл болгодог явдал ч бий.

Ийнхүү «хадагтай хүүхэн», «алчууртай хүүхэн» гэж ураг тогтсон хүүхнийг нэрлэх тусгай үгс бий болжээ. Шинжааны Өөлд ба Цахарын аман ярианд «хүүхэнтэй хүн архи ууна/хөвгүүнтэй хүн гал

зөөнө», «хүүхэнтэй хүнд үг тасардаггүй/хүнтэй газраас мал тасардаггүй» (Га.Гомбо настныг сурвалжилсан тэмдэглэл, 2005), «хүүхэнтэй хүн үг сонсдог/хөвгүүнтэй хүн үг оруулдаг» гэх мэтийн өвөрмөц хэлц үг байдаг. Тухайн газар орны аман аялгуунд бэр гуйхаар очихыг «хэл оруулах», «үг оруулах», «гал оруулах», «гал зөөх», «гал бариулах», «архи зөөх» гэх мэтээр хэлдэгтэй эх сурвалж нэг юм. Газар газрын өвөрмөц зан үйл нь нутгийн аялгууны өвөрмөц үгс бий болох хөрс нь болох мөртлөө орон нутгийн өвөрмөц үгсээр дамжин амилан уламжлагддаг.

Гэвч хуримын зан үйлд «агуулга нь хувирсан ч, хэлбэр ба нэрийдэл нь хувирахгүй» байх үзэгдэл оршоор байдаг. Энэ нь хуримын зан үйлийг тусгасан үгс тухайн зан үйлийн бүрэлдэн тогтворжих ба уламжлагдах явц дахь үйлдлийг харуулах төдийгүй, тухайн зан үйлийг сэргээх, гэрчлэх гэрч болдог. Яг «бидний үг хэл бол бидний түүх мөн»[4] гэгчээр үндэстний үг хэл бол үндэстний түүх соёлын ул мөрийг тодорхойлж байна. Жишээ нь, Шинжааны цахар ярианд «хүргэн хүү хүчтэй, хүзүүний мах мөлжүүртэй» гэх хэвшмэл хэлцийг сурвалж бичгийн тэмдэглэл болоод уг орны хуримын зан үйлтэй уялдуулан судалвал, уг хэлцийг буй болгосон эх сурвалж болох Монголчуудын эртний гэрлэх зан үйлийг сэргээж болох юм. Тухайлбал, «Монголын нууц товчоо»-ны 168 дугаар зүйлд «цагур бэхийг өгье, багалзуур идээрээ ирэдхүн» гэх тэмдэглэл байдаг (Элтэнтэй Арджав, 1986, х.487).

Сүнэд хуримын үеэр «аман хүзүү нуглах», Дархад хуриманд «хүзүү нуглах» гэх мэт ёс байна. Иймээс «хүргэн хүү хүчтэй, хүзүүний мах мөлжүүртэй» гэх хэвшмэл хэллэг нь хүргэн хүүгээр хүзүү нуглуулан хүчийг үзэж байсан ба шинэ хүргэн, бэрд хагас хагас хүзүү мөлжүүлж, хүзүү шиг баг барилдлагтай болохыг билэгдэж байсан.

Мөн хуримлах ёсны ижилхэн нэг ёс заншлыг адил бус нутгийн аялгуу буюу аман аялгуунд ижил төстэй бусаар илэрхийлдэг. Жишээлбэл, хуримын өмнө харьд мордох хүүхнээ төрөл саданд нь залж зочлохыг Ойрдууд ерөнхийдөө «хүүхэн урих», Буриадад «басган зайх», Баргууд «хүүхэн хэсүүлэх», Авганарт «хүүхэн цайлуулах», Алашаад «охин найрлуулах», Цахарт «цай уулгах», Баядууд «цэгээ уулгах» гэх мэтээр ярилцдаг.

“Нэмж өгүүлэхэд адилхан нэг үгийн илэрхийлэх агуулга нь овог аймаг болон нутаг орны онцлогтой байна. Жишээлбэл, «хариу хурим» гэвэл цахар нутагт хүү, хүүхний айл гэрийг босгогч, төрүүлсэн болон мөргүүлсэн эцэг,

эхийн ачлалд хариу талархах”-аар хийх хуримыг зааж байхад (Уудам, Өргөн, 1987, х.217), Алашаа нутагт их хуримын дараа, хуримласан хоёр шинэ гэртээ цай хоол бэлтгэж хуримд оролцсон бүх зочин гийчдийг хариу барих найрыг заадаг (Уудам, Өргөн, 1987, х.487). Энэ нь монгол үндэстний хуримын зан үйлийн орон нутаг ба овог аймагт уламжлал шинэчлэлийн онцлогыг харуулах төдийгүй, гэрлэх зан үйлтэй холбогдох үгс нь тухайн нутгийн хүмүүсийн өвөрмөц соёл, сэтгэцийн тусгал болох мөртлөө аман аялгууны үгсийн санг өвөрмөц болгох бас нэгэн бодит шалтгаан болж байна.

Хорчин түмний хуримын зан үйл нь монгол үндэстний уламжлалт гэрлэх зан үйлээс улбаалж овог аймаг, орон нутгийн онцлогтойгоор хөгжиж ирсэн юм. Иймээс Хорчин хуримын зан үйл нь бусад орны Монголчуудтай нийтлэг шинжтэй байх бөгөөд өвөрмөц онцлог үлэмж их байдаг. Энэ нь хорчин аман аялгууны үгсийн санд тусгалаа олсон байна.

Нэг. Хорчин хуримын зан үйл дэх хүнтэй холбогдох өвөрмөц үгс

Эрдэмтэн Д.Гонгор «Халх товчоон» бүтээлдээ сурвалж бичгүүд дэх “харь шир” гэх хоршоо үгийг зарим орны хуримын зан үйлтэй харьцуулан шинжилж «Монгол овог аймгууд бүхэлдээ төрлөөс гадуур ураглах ёсноос үүсвэрлэн ураг-харь буюу зад-шир хэмээх хоёр үндсэн том хэсэгт хуваагдаж байв» гэжээ (Гонгор, 1990, х.250). Эртний монголчууд хуримын ёс заншлаар үндэслэл баримжаа болгож, нийгмийн анги бүлгийг ялган тогтоож байжээ.

Одоогийн ардын аман ярианд хүүхэн хүний хуримлахыг «харьд өгөх», «харьд мордох» гэх ба «харийн хавьс хугална/үрийн үндэс залгана» гэсэн нь эртний монголчуудын овгоосоо гадна ураглах ёсыг тусгасан байна. Харь ширийг холбож ураг төрөл бололцох бүхий л явцыг хариуцан тохируулагч, элдэв зүйлийн хариуцлагатан байхын хамт эл явцад харгалзсан нэрийдэл ба шинэ ураг төрөлтөн худ худгүй, хүргэн бэр гэх мэт хадам төрхөмийн ураг төрлийн сүлбээний шинэ гишүүн гарч ирдэг. Доор Хорчин зоны хуримын зан үйл дэх хүнтэй холбогдох өвөрмөц үгсээс шинжлэн үзье.

Хэлэлцээний хүн-зууч хүнийг хэлнэ. Хөвгүүний талаас хүүхний талд очиж бэр гуйх хүнийг заадаг.

Сүйтэй охин-нэгэнт ураг тогтсон хүүхнийг нэрлэнэ. Хорчинд «сүйг эвдлэхээрээ сүмийг эвдэл» гэж сүйтэй охиныг дахин өөр хүн гуйхыг

ихэд цээрлэдэг. Мөн “архи уулгасан охин” гэж ч хэлдэг.

Төгс хүн-Хорчинд эрэмдэг зэрэмдэг биш, хүү охин тэгш дэлгэрсэн, эцэг эх элэг бүтэн хүнийг хэлдэг. Хорчинд зууч болох хүн болон мөргүүлсэн эцэг, эхийг сонгохдоо билэгдлийг бодолцож заавал ийм хүнийг сонгодог заншилтай.

Хүчин хүргэн-Хорчинд хүүгүй айл буюу балчир хүүтэй айлынх нь хүүхэндээ авсан хүргэнийг хэлнэ. Хуримласны дараа хүүхний талд сууж хүчээ өргөхөөс үүсэлтэй нэршил болно.

Үүнээс гадна Хорчин ардын аман ярианд «хурим төр хийх», «хурим төрийн явдал» гэж хэлдэг нь «хуримын явдал»-д төрийн ёслолын шинж байхыг зохих хэмжээгээр харуулж байна. Үүн лүгээ адил Буриад монголчуудын дотор «төр хийх» гэвэл мөн л «хурим хийх»-ийг хэлдэг бол «төрийн бэлэг» гэдэг нь хуримд оролцогчдын өгөх бэлгийг заадаг. Энд «хурим» ба «төр» гэдэг хоёр үгийн утга дүйцэж байна.

Бас Дархад хуримын явцын зарим хариуцлагатны нэрийг «хуримын амбан, хүргэн түшмэд, хуримын дэмч, хонжин»-д «амбан, түшмэд, дэмч, хонжин» зэрэг төрийн албан тушаалтны нэрийг хуримын хариуцлагатны нэрд хэрэглэж байгаа нь хуримын ёсыг төр засгийн ёсоор хүндэтгэн дээдэлж байсны бас нэгэн илрэл болно. Үүнд, хорчин түмний хуримын ёслолд хүү хүүхний талд бүр түрүү худ, түшмэл худ, хүргэн дагасан, охин дагасан, зангида, гал тогооны дарга ба олон хавсрагчийг тусгайлан тохируулдаг мөртлөө хоёр талаараа харилцан «ураг ноёд» гэж дуудан хүндэтгэдэг нь төрийн ёслолын чанарыг агуулсан бодит илрэл болно.

Ураг ноёд-хуримын үеэр хүү хүүхний аль нэгэн талыг төлөөлөн нөгөө талын хуриманд оролцогсдыг заана. Үүнд хүүхний талаас ирсэн ураг ноёд нь хамгийн хүндтэй байдаг.

Түрүү худ-хуриманд оролцсон хүү хүүхний ойр төрлийн дотор хамгийн ахмад хүндтэй хүнийг хэлнэ. Хуримын үед түрүү худын суусан ширээг түрүү ширээ гэж хэлдэг.

Түшмэл худ-хуриманд оролцсон хүү хүүхний талын дэд хүндтэй хүн, бас дагуур худ гэдэг.

Хүргэн дагасан-хуримын ёслолын явцад шинэ хүргэнийг дагаж, шинэ хүргэн шиг хувцаслан түүнийг хамжин олон ёслолыг гүйцэтгэн хийдэг хүн юм. Энэ хүн нь уран цэцэн байхын зэрэгцээ дуулж, бүжиглэх авъяастай, тоглоом шоглоом даамтгай зантай хүн байх хэрэгтэй.

Хүүхэн дагасан-Хүүхнээ хүргэж ирсний дараа гурав хоногийн эргэлт болтол хүүхнийг дагаж хүргэний гэрт суух эхийн үетэй (дайны) хүнийг

заадаг. Олонхдоо шинэ бэрийн төрсөн эх нь хүүхнээ даган суудаг.

Зангида-«занги» гэвэл 1. Дээс үдээс зэргийг хөв бус уяа, зангилга ч гэдэг, занги уяах; 2. (хуучин) эе зөвлөл: «Энэ эеэ бүү эвдэгтүн, эе зангиа бүү талдадхун, захаа бүү тамдуулхун» (Монголын нууц товчоо §126) (Цэцэнцогт, 1988, х.2306). Хорчин аман аялгуунд зангида гэвэл хуримын бүх явцыг эвлүүлэн зохицуулах хуримын даргыг хэлдэг. Тус үг нь «занги+да» гэх бүтэцтэй байж «занги» гэх үгийн хоёрдугаар утгын суурин дээр бий болсон байдалтай.

Найз найга-Бэрийг хүргэж ирэгсдийн доторх шинэ бэрийн шууд төрөл саданг заадаг. Бас гол худ гэдэг. Найз найга буюу гол худ бологсдод ураг ноёдын ширээ буусны дараа дахин ширээ будаа засахыг найзын ширээ буюу найзын хурим гэнэ. Энэ найзын ширээнд голдуу найз найга нараас хүүгийн гэрийн эцэг, эхэд хүүхнээ өгөх ёслол хийдэг.

Мөргүүлсэн эцэг эх-Хорчин түмэн хүүдээ бэр буулгах буюу хүүхнээ хүргэнд мордуулахдаа айл аймгаасаа үр хүүхэд тэгш, бүрэн төгс, ивээл жилтэй хүнийг сонгож, хүү бэр эсвэл хүргэн охиндоо мөргүүлсэн эцэг эх болгодог. Иймээс Хорчин аман аялгуунд энэ тухай нэг өвөрмөц үгс бий болжээ. Тухайлбал мөргүүлсэн эцэг, мөргүүлсэн эх, мөргүүлсэн охин, мөргүүлсэн хүргэн, мөргүүлсэн хүү, мөргүүлсэн бэр гэх мэт.

Хоёр. Хорчин хуримын зан үйл дэх бэлэг сэлттэй холбогдох үгс

Монголчуудын хуримын зан үйлийн явцад бэлэг сэлт хүргэх нь нэг зүйлийн ёслол, журам болон хэвшжээ. Үүнд, Хорчин хуримын ёслолын үеийн бэлэг сэлтийг шинж чанараар нь гол төлөв гурван зүйлд хувааж болно. Үүнд:

Нэгд, харь овгоос хөдөлмөр хүчний гишүүнийг оруулан авахын нөхвөр төлөөсийн шинж бүхий шинэ хүргэний талаас охины талд өгөх бэлэг сэлтийг заана. Тухайлбал, бэлэг золио тушаах, эхийн цагаан сүүний хариу өгөх гэх мэт. Нөгөө нь хуримлах хүү охинд төрөл садан найз нөхдөөс нь хуримын явдалд нэмэр хандив, бэлэгдэл зөгнөл болгох үүднээс өгөх тусламж дурсамжийн шинжтэй бэлэг сэлтийг хэлнэ. Тухайлбал, хуримын тал (хуримын бэлэг) өгөх, мөн шинэ бэрээс хадам лугаа уулзах золголтын бэлэг болно. Энэхүү зүйлийн бэлгийг шибэд гэж хэлдэг. Голцуу шаахай, хавтгаас бүрдэж, тэдгээрийг шибэдийн шаахай, шибэдийн гутал, шибэдийн хавтаг гэж хэлдэг. Энэ бэлэг нь маш ховор нандин эд болохоор Хорчин аман аялгуунд ховор хомсыг шибэд хувад

гэж хэлдэг болжээ. Даруй шибэд хубад юм, шибэд хувад зантай гэх мэт.

Монголчуудын бэлэг сэлт хүргэх заншил нь их эртний уламжлалтай. Тухайлбал «Монголын нууц товчоо»-нд Есүхэй баатар Тэмүжинд Дай сэцэний охиныг гуйж «хөтөл морио бэлэг өгч» гэж тэмдэглэжээ (Баяр, 1980, х.112).

Энэ нь тухайн үед хүүгийн талынхан хүүхний талд бэлэг хүргэж байсны гэрч болно. Бас Чанчун бумбын «Баруун этгээдэд аялсан тэмдэглэл»-д «Ураг хуримын цуглаан найрт таван зуун газрын доторхи аймгийн түрүүчид бүр цэгээгээ тээж ирэн хавсран оролцдог» (Доронадив, 1985, х.87) гэх тэмдэглэл байх ба “«Ойрд цааз»-д «жил бүр Дөчний дөрвөн гэр хөвгүүнд авч өгтүгэй. Арван хөвгүүн дэмжиж нэг гэр авч өгтүгэй. Гэр авч эс өгхүл цааз нь хоёр тэмээ, таван морь, арван хонь авах»” гэж нутаг олноор дэмжин хавсарч хурим хийх нь аль эртнээс хэвшиж заншсан төдийгүй хууль цаазаар мөн баталгаажуулж байсан байна (Хүрэлшаа, Саруул, 2003). Хууль цааз бол хүн төрөлхтний заншлын хуулийн дүрэмжүүлэлт мөн. Гэхдээ энэхүү заншил нь эл газар орны Монгол түмний дунд орон нутгийн онцлогтойгоор уламжлагдаж дэлгэрсэн юм. Жишээлбэл, Өөлдөд «дэм сэлбэг өгөх», Ордост «сааль тусаах», Хорчинд «хуримын тал өгөх» гэх мэт.

Гурав. Хорчин хуриманд гүйцэтгэх үйлтэй холбоотой үгс

Хорчин хуримын зан үйл нь монголын эртний ёс заншлыг залгамжлахын хамт харь зэргэлдээ үндэстэн угсаатны хуримын зан үйлийн зарим заншлыг шингээн, эрэмбэ цэгцтэй, өөрийн онцлогтойгоор хэвшин загварчлагджээ. Үүнд, доорх хэдэн зан үйл нь бусад орны хуримын зан үйлээс ялгаатай байна.

Хэлэлцээ орох: Зууч явуулж бэр гуйлгахыг хэлнэ.

Архи уулгах: Архи уулгахад бага архи буюу аман архи уулгах, их архи уулгах гэсэн 2 зүйл бий. Үүнд:

Бага архи буюу аман архи уулгавал хүү, хүүхний ургийн явдал нэгэнт тохирч тогтосныг зарлаж байгаа юм. Хэсэг хугацаа өнгөрөөд их архи уулгах ёслол болдог. Энэ ёслолоор хоёр талынхан бэлэг сэлтийн тухай хэлэлцэж тохиролцдог.

Гэр үзэх: Энэ ёслол нь ойрын үед өргөн явагдаж байна. Аман архи уулгаж дууссаны дараа их архи уулгахаас өмнөхөн охины талынхан хүүгийн талд очиж тэднийх хэрхэн амьдарч байгааг үзэхийг хэлнэ. Энэ үед хүүгийн талынхан охины талынхныг хүндэтгэн угтаж, буцах үед нь

бас бэлэг сэлт өгдөг заншилтай.

Мал бэлгийн хурим хийх: Хүргэний тал хуримнаар тохиролцсон ёсоороо бэлэг сэлтээ бэлтгэж охины талд хүргэж хурим хийхийг хэлнэ. Бас бэлэг хүргэх хурим гэж нэрлэдэг.

Өдөр тушаах: Хүүгийн тал лам төлөгчөөр хуримын өдрийг үзүүлж, тогтсоны дараа хүүхний талд мэдэгдэхийг өдөр тушаах гэнэ.

Шүүс бэлдэх: Их хурим болохоос 2-3 хоногийн өмнө хүүгийн тал хуримд хэрэглэх архи, махыг хүүхний талд хүргэхээр очихыг шүүс тушаах гэнэ.

Хүргэн мордох: Шинэ хүргэн хэдэн хүнтэй хамт бэр буулгахаар мордон гарахыг хэлнэ. Мөн саадаг мордох ч гэдэг.

Охин хаших: Хуримын өдөр бэр болох охинтой нас чацуу охид ирж, харьд мордох охинтой ярилцаж, наадах үйлийг хэлнэ. Энэ нь нэг талаараа харьд мордох охины сэтгэлийг баясгах, нөгөө талаараа харьд мордох охиныг оргож, бусгахаас сэргийлж байгаа утгатай.

Шагайтын хурим тавих: Бэр буулгахын өмнөх шөнө охиныг хашиж суусан охид ширээ засаж, хүргэн ба хүргэн дагагчийг элдэв зүйлээр тэнсэн найралдахыг хэлнэ. Бас шансэн ширээ тавих гэдэг. Хорчин хуримын энэхүү ёслолд шагай булаалдах, багалзуур идэж, аман хүзүү мушгидаг агуулга нэгэнт үгүй болсон байна. Гэвч Хорчин Монголчууд мөн шагайтын хурим гэж нэрлэсээр байна. Иймэрхүү хуримын зан үйлийг тусгасан үгс нь тухайн зан үйлийн бүрэлдэн тогтворжих ба сэргээн уламжлагдахад чухал үйлдэл үзүүлдэг байна.

Хүргэн хувцаслах: Шагайтын ширээ дууссаны дараа хүргэн ба хүргэн дагагчийг хоол идүүлж, шинэ хүргэнд шинэ хувцас өмсүүлэхийг хэлнэ. Энэ үйлийг голцуу охины талын бэргэн гүйцэтгэгчдэд.

Охин хүргэх: Охиноо хүүгийн талд хүргэж очихыг заана.

Охин тушаах: Охин хүргэгчид охиноо хүүгийн эцэг, эхэд хүргэн өгч сайтар харж хандахыг хүсэмжлэхийг хэлнэ.

Охин дагах: Хүүхнийг хүргэж ирсэн эх, авга болон нагац эгчээс нэг хүн хоцорч шинэ бэрийг гурван өдөр даган сууж, бэр болох ёс заахыг хэлнэ.

Охин эргэх: Хуримаас хойш гурав дахь өдөр нь хүүхний талынхан боов боорцог, амтат жимс зэргийг ачааллан ирж, хүүхнээ эргэн үзэхийг хэлнэ. Энэ өдрийг «эргэлтийн өдөр» гээд их хуримаас багахан хурим болдог. Бас цагаан сарын үеэр харьд мордсон охиноо эргэн үзэхийг мөн л охин эргэх гэж хэлдэг. Иймээс Хорчин аман аялгуунд «эргэлт» гэх өвөрмөц үг бий болжээ.

Жишээлбэл, эргэлтийн юм, эргэлтийн бэлэг гэх мэт.

Охин зээлэх: Бэр болсон хүүхнээ хадмаас нь чөлөө гуйж, төрхөмд нь тогтсон хугацаагаар авч суухыг хэлнэ.

ДҮГНЭЛТ

Нутгийн аялгуу болон зан үйл хоорондоо нягт уялдаатай байдаг. Орон нутгийн өвөрмөц зан үйл нь нутгийн аялгууны өвөрмөц үгс бий болох хөрс төдийгүй орон нутгийн өвөрмөц үгсээр дамжин амилан уламжилдаг байна. Хорчин зон олны хуримын зан үйл нь эртний монголын хуримлах ёсноос эх сурвалжтай бөгөөд газар нутаг, овог аймгийн онцлогтой хөгжиж ирсэн байна. Уг зан үйлтэй холбогдох үгсэд хуримнаар хийгдэх үйлдлийн ул мөр хадгалагдаж, орон нутгийн онцлогийг ч илэрхийлж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

[1] 温端政 《方言与民俗》 《中国语文》 1988年 第三期

Уудам, Өргөн, Ч. (1987). *Монгол хурим*. Хөххот: Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо
Зохиогчийн 2005 оны 8 сард Шинжяны уйгурын өөртөө засах орны Бортал Монгол үндэстэний өөртөө засах Зиугийн Бортал хотын Га.Гомбо настныг сурвалжилсан тэмдэглэл

[4] 邵敬敏 : 《文化语言学中国潮》 语文出版社 1995年 p. 48

Элтэнтэй Арджав. (1986). Монголын нууц товчоо-Сийрүүлэл тайлбар» Хөххот, Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо

Гонгор, Д. (1990). Халх товчоон (доорд) Хөх хот: Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо

Цэцэнцогт. (1988). Монгол үгсийн язгуурын толь. Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо

Баяр. (1980). Монголын нууц товчоо. Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо

Доронадив. (1985). Ойрд цааз. Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо

Хүрэлшаа, Саруул (2003). Зан үйл (дээд). Хөх хот: Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо